



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/81

Ховд


Нүүрс тээвэрлэлтийг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, 29.1.6-ын “а”, “л” заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Улсын Онцгой комиссын 02 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр шийдвэр, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 06 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрээр дамжуулан Булган боомтын чиглэлд нүүрс тээвэрлэх хөдөлгөөнийг 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 3 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд түр хориглосугай.

2.Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчилж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга /Б.Алтанбадралт/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Хилийн цэргийн 0130 дугаар анги /О.Азхүү/, Гаалийн газар /О.Лхагва-эрдэнэ/, “МоЭнКо” ХХК-ний дэд захирал /Ж.Оюунчимэг/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, нүүрс тээвэрлэлтийн аж ахуйн нэгжүүдийн дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/81 Ch

02 00363